

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА **/Шинэчилсэн найруулга/**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаа болон Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.7 дахь хэсэгт “Ашгийн төлөө хуулийн этгээд нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх эрхтэй.” гэж, мөн зүйлийн 26.8 дахь хэсэгт “Хуулийн этгээд хуульд заасан зарим үйл ажиллагааг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ. Үйл ажиллагааг эрхлэх эрх тусгай зөвшөөрөл авсан өдрөөс үүснэ.” гэж, 189 дүгээр зүйлийн 189.2 дахь хэсэгт “Нийгэм, хувь хүний ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор зарим төрлийн гэрээг гагцхүү төрийн эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр байгуулж болно. Тусгай зөвшөөрөл олгох журмыг хуулиар тогтооно.” гэж, мөн зүйлийн 189.3 дахь хэсэгт “Тусгай зөвшөөрлийн үндсэн дээр байгуулсан гэрээ нь эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрлийг авснаар хүчин төгөлдөр болно.” гэж тус тус заасныг удирдлага болгон Зөвшөөрлийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.19-д “Төрөөс бизнес эрхлэгчдэд олгож байгаа тусгай зөвшөөрлийн тоог гурав дахин цөөрүүлж, хүчинтэй байх хугацааг уртасган, давхардсан хяналт шалгалт, хүнд суртлыг арилгана.”, 2.12-т “Зах зээл дэх шударга өрсөлдөөнийг дэмжиж, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчинг сайжруулна.”, 2.62-т “Уул уурхайн үйлдвэрлэл дэх төрийн оролцоог зохистой хэмжээнд байлгаж, Кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгож, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээг хөнгөн шуурхай болгоно.”, 5.2.7-д “Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байх эрх зүйн орчинг бүрдүүлж, иргэдийн эрхийг баталгаажуулна.” гэсэн зорилтуудыг дэвшүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 2-т зөвшөөрөл, лицензийн тоог цөөлж, лиценз авдаг олон шат, дамжлагыг багасгах, бизнест ээлтэй эрх зүйн орчинг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хохирол учруулж болзошгүй, орчиндоо аюултай аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, хязгаарлагдмал нөөц бүхий нийтийн өмч, эрхийг эзэмших, ашиглахад төрөөс зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, цуцлах, зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгох зорилгоор Зөвшөөрлийн тухай хуулийг боловсруулахаар тогтсон болно.

Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил

шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулах үүднээс Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 2001 оны 02 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан байдаг.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон салбарын шинжтэй 100 гаруй хуулиар тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох харилцаа ямар нэг хэмжээнд зохицуулагдаж байгаа бөгөөд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнээс хойш хугацаанд уг хуульд 69 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байдаг ба нэр томьёоны зөрчил үүсэх, зарим талаараа хуулийн уялдаа холбоо алдагдахад хүргэсэн байна.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон салбарын шинжтэй бусад хуулиар бий болгоогүй зөвшөөрлийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиар бий болгох хууль зүйн практик ч мөн тогтсон байна.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 19 чиглэлээр 103 ерөнхий төрөл, энэхүү төрөл нь 210 гаруй дэд төрөлд хуваагдан тусгай зөвшөөрөл олгохоор байгаа боловч салбарын бусад хууль тогтоомж, эрх зүйн дэд актаар тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл /олон удаа болон нэг удаагийн шинжтэй/-ийг шинээр бий болгох, ерөнхий төрлийг задалж олгох байдал түгээмэл болсон байна.

Өөрөөр хэлбэл, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заагаагүй зөвшөөрлийн чиглэл, төрлөөр зөвшөөрөл олгох харилцаа явагдаж байгаа бөгөөд Монгол Улсын хэмжээнд 2016 оны байдлаар 54 байгууллага 914 төрлийн зөвшөөрөл олгож байна гэсэн судалгаа хийгдсэн байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2001 оны “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 17 дугаар тогтоолд тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуультай нийцүүлэн, зохих хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар санал боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Байгалийн ургамлын тухай, Ан агнуурын тухай, Амьтны аймгийн тухай, Ойн тухай, Усны тухай хуулиар олгох зөвшөөрлийг энэ хуультай уялдуулан хянан үзэж, тодорхой санал боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацаатай үүрэг Засгийн газарт өгөгдсөн ч одоог болтол бүрэн хэрэгжээгүй байна.

Дээрх хууль зүйн болон практик үндэслэл, шаардлагын дагуу Аж ахуйн үйл ажиллагааны тухай хуулийг шинэчлэн найруулах хуулийг төслийг боловсруулж хуулийн нэрийг Зөвшөөрлийн тухай гэж өөрчиллөө.

Үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэх, байгалийн баялаг, төрийн нийтийн зориулалттай өмчийг ашиглахад эрх бүхий этгээдээс зөвшөөрөл

олгох, олгосон зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, түүнчлэн зөвшөөрлийн ангилал, төрөл, тэдгээрийн бүртгэл, Монгол Улсын нутаг дэвсгэрт хориглох үйл ажиллагааг тогтоохтой холбоотой нийтлэг харилцааг хуулийн төсөлд тусгана.

Хууль тогтоомжийн тухай 25 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулж, хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасны дагуу 8 бүлэгтэйгээр боловсрууллаа.

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, зөвшөөрлийн хууль тогтоомж, үйлчлэх хүрээ, нэр томъёоны тодорхойлолт, зөвшөөрөл олгох, сунгах, шинээр бий болгоход баримтлах зарчим, тэдгээрийг хэрэгжүүлэх хүрээг тусгалаа.

Тухайлбал, энэ хүрээнд хуульд зааснаас бусад тохиолдолд Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, төрийн зарим чиг үүргийг хуульд заасны дагуу шилжүүлэн авсан этгээд аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглох зохицуулалтыг тусгах бөгөөд хуулийг зөрчсөн тохиолдолд эрх бүхий этгээд хариуцлага хүлээх үндэслэл болохоор тусгасан болно.

Түүнчлэн Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.8 дахь хэсэгт зааснаас үзэхэд тусгай зөвшөөрөл нь тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах “эрх” гэж ойлгогдохоор заасан байдаг бол Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад зааснаар тусгай зөвшөөрлийг “албан ёсны баримт бичиг” гэж заасныг залруулж хуулийн төсөлд тусгасан.

Хуульд заасан тохиолдолд зөвшөөрлийг олгох, сунгах ажиллагааг хөнгөвчилсөн буюу хялбаршуулсан горимоор явуулах, түүнчлэн энэхүү харилцааг нэг цэгийн үйлчилгээний болон цахим хэлбэрээр зохион байгуулж болох ерөнхий зохицуулалтыг тусгалаа.

Түүнчлэн зөвшөөрлийг шинээр бий болгоход тухайн үйл ажиллагааг төрөөс зохицуулах шаардлагатай эсэх, зөвшөөрөл нь зохицуулалтын зохистой арга хэрэгсэл мөн эсэх, зөвшөөрөл нь нийгэм, эдийн засгийн хувьд үр ашигтай байх эсэхэд судалгаа, үнэлгээ хийх зарчмыг баримтлан олон улсын жишиг, стандартыг харгалзахаар тусгаж, судалгаа, үнэлгээ хийх ажиллагааг Засгийн газар батлахаар заалаа.

Хоёрдугаар бүлэгт зөвшөөрлийн ангилал, зөвшөөрлийн агуулга, зөвшөөрлийн код, зөвшөөрлийн хугацаатай холбоотой зохицуулалтыг тусгах бол хуулийн төслийн гуравдугаар бүлэгт зөвшөөрлийг олгох эрх бүхий этгээд, тэдгээрийн бүрэн эрхийг тусгана. Тухайлбал, зөвшөөрлийг 2 ангилах ба хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг 5 жилээс доошгүй, энгийн зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаагаар олгохоор хуулийн төсөлд тусгалаа.

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт зөвшөөрлийг олгох, сунгахтай холбоотой ерөнхий зохицуулалтыг тусгана. Харин зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, эдгээр харилцаатай холбоотойгоор үүсэх үр дагавартай холбоотой зохицуулалтыг хуулийн төслийн тавдугаар бүлэгт, зургадугаар бүлэгт зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, зөвшөөрлийн бүртгэл, мэдээлэл, цахим сангийн талаар тусгалаа.

Хуулийн төслийн долоодугаар бүлэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт эрхлэхийг хориглох үйл ажиллагаа болон зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаа чиглэл, төрлийг тус тус тусгалаа.

Тусгай зөвшөөрлийг 13 чиглэлээр олгох ба нийт 285, энгийн зөвшөөрлийн мөн 13 чиглэлээр олгох ба 163 нийт 448 зөвшөөрлийг олгож болохоор тусгаад байна.

Наймдугаар бүлэгт зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хянах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой харилцаа болон бусад зохицуулалтын талаар тусгасан.

Зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээр олгосон нэг удаагийн болон олон удаагийн шинжтэй бүх зөвшөөрлийн бүртгэл, зөвшөөрөлтэй холбоотой нийтлэг мэдээллийг агуулсан зөвшөөрлийн цахим нэгдсэн сантай байх ба зөвшөөрөл олгох, бүртгэх эрх бүхий этгээд зөвшөөрлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих, зөвшөөрлийн тухай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагын талаар санал дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшил, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл Ерөнхий сайдын дэргэд ажиллахаар тусгалаа.

Хуулийн төсөл батлагдсаны дараа дараах эерэг нөлөөг бий болгоно гэж үзэж байна. Үүнд:

1.Хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх Иргэний хуулийн суурь үзэл баримтлалыг баталгаажуулж, Монгол Улсын нутаг дэвсгэрт эрхлэхийг хориглосон үйл ажиллагаа болон зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаа чиглэл, төрөл, эдгээр харилцаатай холбоотой суурь харилцаа тодорхой болно.

2.Зөвшөөрлийг олгох, сунгах цахим хэлбэрээр зохион байгуулж болох зохицуулалт хуульчлагдаж, иргэд чирэгдэл хүнд сурталгүй төрийн үйлчилгээг хүргэх, зөвшөөрөл олгох харилцаа ил тод, хяналттай болно.

Өөрөөр хэлбэл лицензийн тоог цөөлж, лиценз авдаг олон шат, дамжлагыг багасгах, бизнест ээлтэй эрх зүйн орчинг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд хохирол учруулж болзошгүй, орчиндоо аюултай аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, хязгаарлагдмал нөөц бүхий нийтийн өмч, эрхийг эзэмших, ашиглахад төрөөс зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, цуцлах, зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцаа боловсронгуй болно.

3.Зах зээлийн харилцаан дахь оролцогчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээрийг дэмжих зохицуулалтыг оновчтой хийх, түүнчлэн зөвшөөрөл эзэмшигчдэд тавигдах шаардлага тодорхой болох, нөгөө талаас үндэсний аюулгүй байдал, иргэдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах цэгцтэй механизмыг бүрдүүлэхэд чухал алхам болно.

4. Хууль тогтоомжийн хийдэл, зөрчил арилж, уялдаа холбоо сайжирна.

Зөвшөөрлийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний хуульд нэмэлт оруулах тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай зэрэг 44 хуулийн төслийг боловсрууллаа.

Холбогдох байгууллагаас хуулийн төслийг боловсруулах явцад саналыг авсан болно. Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 9943 тоот албан бичгээр санал дүгнэлт авахаар илгээсэн бөгөөд санал ирүүлээгүй тул тусгайлан өгөх саналгүй гэж үзлээ.

---o0o---